



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/51

Баян-Өндөр сум

Эд хөрөнгийн тооллого явуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоол, Байгууллагын “Өмч хамгаалах зөвлөл”-ийн ажиллах журмын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Эрүүл мэндийн газрын 2026 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллого явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2026 оны хагас жилийн тооллого хийх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эд хөрөнгийн тооллогыг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хүртэл зохион байгуулж, холбогдох заавар, журмын дагуу бүртгэл хийж, тооллогын дүн мэдээг нэгтгэн, тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ



Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны  
06 дугаар сарын 02-ны өдрийн  
А/Б/ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эрүүл мэндийн газрын 2026 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллого  
хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

| №  | Овог нэр      | Албан тушаал                                                                       | Тооллого хийх байршил      |
|----|---------------|------------------------------------------------------------------------------------|----------------------------|
| 1. | Г.Энхзаяа     | Сувилахуй болон хөнгөвчлөх, тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн                | Захиргааны IV-р байр       |
| 2. | Б.Нямсүрэн    | Цахим эрүүл мэнд, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн |                            |
| 3. | Н.Мөнх-Ундраа | Архив бичиг хэргийн ажилтан                                                        |                            |
| 4. | Б.Алтанзагас  | Нярав                                                                              | Нийгмийн эрүүл мэндийн төв |
| 5. | А.Хонгорзул   | Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн                       |                            |
| 6. | Б.Батцэцэг    | Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан                                    |                            |

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны  
06 дугаар сарын 02 ны өдрийн  
А/Б/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2026 оны хагас жилийн тооллого  
хийх ажлын төлөвлөгөө

| №  | Үйл ажиллагаа                                                                                                          | Хугацаа       | Хариуцах эзэн                 |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|-------------------------------|
| 1. | Байгууллагын үндсэн хөрөнгө, эргэлтийн болон хангамжийн материалын тооллогыг нэг бүрчлэн хийж, бүртгэлийн тулгалт хийх | 2026.06.04-09 | Өмч хамгаалах зөвлөл          |
| 2. | Албан хаагчдын эд хөрөнгийн картын бүртгэлийг тулган шалгаж, өөрчлөлт шинэчлэлтийг хийх                                | 2026.06.04-09 | Нярав                         |
| 3. | Хөрөнгө хариуцагч болон хөрөнгийн карт эзэмшигчдийн бүртгэлийг шинэчлэн баталгаажуулах                                 | 2026.06.06-09 | Нярав                         |
| 4. | Тооллогын дүнг нэгтгэн тайлан, дүгнэлт боловсруулж удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх                            | 2026.06.30    | Өмч хамгаалах зөвлөлийн дарга |